



# СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

# МЭДЭЭ

№102 /316/

2022.05.31

Цаг үе, үйл явдал

## ХӨВСГӨЛ НУУРЫГ ХАМГААЛАХ, БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ҮЕ ШАТТАЙ АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хурэлсүхийн санаачилгаар "Хөвсгөл нуурыг хамгаалах үндэсний чуулган"-аас нууранд живсэн тээврийн хэрэгслийн байршил, гүнийг нарийвчлан тодорхойлж, зураглал, суурь судалгаа хийж, живсэн тээврийн хэрэгслийг 2024 оны дотор үе шаттай татан гаргах тухай зөвлөмж гарсан.

Тэгвэл тус зөвлөмжийн дагуу Батлан хамгаалахын сайдаар ахлуулсан ажлын хэсэг хуралдалдаа. Хуралд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэд сайд Г.Түвшэндорж, ОБЕГ-ын тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга хурандаа Ж.Чүлтэмсүрэн, БОАЖЯ-ны Усны бодлого зохицуулалтын газрын дарга Г.Хоролмаа, Япон Улсын "Ниппон Селвиж" группийн мэргэжилтэн Акари Ватару, Усны газрын дарга Ш.Мягмар болон ажлын хэсгийн бусад гишүүд оролцлоо.

Энэ үеэр ОБЕГ-ын тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга хурандаа Ж.Чүлтэмсүрэн Хөвсгөл нуурт живсэн тээврийн хэрэгслийг эрэн хайх, илрүүлэх, судалгаа, шинжилгээ, авч хэрэгжүүлсэн ажлын явц байдал, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар мэдээлэл хийлээ. Түүнчлэн "Ниппон Селвиж" группийн мэргэжилтэн ноён Ватару Араки Хөвсгөл нуурт живсэн тээврийн хэрэгслийг эрэн хайх, илрүүлэх, судалгаа, татан гаргах ажиллагааны чиглэлээр Япон Улсын талаас тус нуурын байгалийн тогтоц, техник хэрэгслийн живсэн байх магадлалтай

газруудын хэмжээ, байршлыг агаараас тандах, улмаар нарийвчлан тогтооход шаардлагатай судалгааны арга зүй болон цаашид ашиглагдах техник хэрэгслийг тодорхойлсон үйл явцыг танилцуулсан юм. Албаны хүмүүсийн танилцуулга, мэдээллийн дараа Хөвсгөл нууранд живсэн машин, техникийг татан гаргах ажиллагааны хүрээнд Монгол-Японы талууд 2 талын төлөвлөгөөг боловсруулж далайд живсэн техник хэрэгслийг татан гаргах чиглэлээр 130 гаруй жилийн турш үйл ажиллагаа явуулж буй Япон Улсын "Ниппон салвэйж" компаниас илрүүлэг хийх шумбагч дрон хэрэгслийг эхний ээлжид татан авч ажлыг эхлүүлэх шийдэлд хүрэв. Мөн шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хүн хүчний тооцооллоо нарийвчлан гаргаж хамтарсан ажлын төлөвлөгөө боловсруулах юм. Уг арга хэмжээ "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийн "Ногоон хөгжил"-ийн нэгдүгээр үе шат буюу 2021-2030 онд цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эх зэрэг онцлог экосистемийг тусгай хамгаалалтад авч унаган байгалийг хамгаалах зорилтын хүрээнд өрнөж байгаа юм. Уг ажлыг Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар БХЯ, БОАЖЯ, Гадаад харилцааны яам, ОБЕГ, ТТХГ, Усны бодлого зохицуулалтын газрын ажлын хэсгүүд хамтран хэрэгжүүлэх юм.

## УУЛЫН ТУСГАЙ БАТАЛЬОНЫ "УУЛЫН АНХАН ШАТНЫ СУРГАЛТ"



**Зэвсэгт хүчний 331 дүгээр анги**  
Уулын тусгай батальоны бие бүрэлдэхүүн энэ сарын 16-20-ны өдрүүдэд "Уулын явган цэргийн анхан шатны сургалт"-ыг зохион байгуулж явууллаа.

Тус сургалт дадлагыг ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Х.Золжаргал удирдаж, уулын бэлтгэлийн ахлах офицер ахмад Э.Энхбаатар, Уулын нэгдүгээр ротын ажиллагааны офицер ахлах дэслэгч Б.Даваадорж, Уулын хүнд ротын салааны ахлагч, тасгийн захирагч ахлах ахлагч Ц.Нямдаваа, Уулын хөтөч, сургагч багш ахлах ахлагч Х.Отгонхүү, Уулын нэгдүгээр ротын гранатмётчин ахлагч Г.Баярцэнгэл, буудагч дэд ахлагч Ц.Золзаяа нарын сургагч багш нар 5 өдрийн туршид үр дүнтэй зохион байгуулав. Сургалтад ангиас 70 цэргийн алба хаагч хамрагдсаны дээр Хилийн цэргийн 0165 дугаар ангиас анх удаа 3 цэргийн алба хаагч хамрагдсан нь онцлог байлаа.

Сургалтыг уулархаг газар оронд бүлгээр болон тасгаар хөдөлгөөн үйлдэх арга, хаданд авиралт хийх, буух, бөхлэгээний талбай байгуулах арга техник, өндрөөс олсоор буух, олсоор бөхлэгээний зам тавих арга барил,

татан гаргалт хийх арга техник зэрэг хичээлийн 4 цэгээр зохион байгуулан явуулж, ууланд авирахад өргөн хэрэглэгддэг 10 төрлийн зангилааг заангидах арга барилыг эзэмшүүлэв.

Түүнчлэн сургалтын үеэр соёл, хүмүүжлийн ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу явуулсан бөгөөд сургалтын бүлгүүдийн дунд "Гоц авьяастан бүлэг" шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа. Эл тэмцээнд 5 бүлэг оролцож ахмад Ч.Адъяа даргатай II бүлэг тэргүүн байр эзэлсэн бол танин мэдэхүйн "АХА" тэмцээнд ахлах ахлагч Э.Шинэбаяр тэргүүн байр эзлэв.

Энэ удаагийн "Уулын явган цэргийн анхан шатны сургалт"-ыг ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтарсан уулын явган цэргийн III шатны сургалтад хамрагдаж бэлтгэгдсэн сургагч багш нараар богино хугацаанд хээрийн байрлалд бие даан явуулсан нь онцлог байлаа. Мөн ирэх сард зохион байгуулагдах ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтарсан уулын явган цэргийн IV шатны сургалтад хамрагдах бүрэлдэхүүний бэлтгэлийг бүрэн хангасан сургалт, дадлага болсноороо ач холбогдолтой юм.

Ахлах дэслэгч Б.ГЭРЭЛТ-ОД

## "ЦЭРГИЙН АЛБАНЫ БЭЛТГЭЛ" СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

**Багануур дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб**

Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Цэргийн штабын 2022 оны цэргийн сургалт, бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн I зэргийн бэлтгэл үүрэгтийг "Цэргийн албаны бэлтгэл" сургалтыг Зэвсэгт хүчний 353 дугаар ангитай хамтран энэ сарын 23-27-ны өдрүүдэд зохион байгуулж явууллаа.

Сургалтад хамрагдсан бүрэлдэхүүнийг Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн захирагч хурандаа Ш.Аюурзана, захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Э.Мэндсайхан, дайчилгааны офицер хошууч Д.Энхтүвшин нар хүлээн

авч, ангийн үйл ажиллагаатай танилцуулсан юм.

"Цэргийн албаны бэлтгэл" сургалтад I зэргийн 30 бэлтгэл үүрэгтийг хамруулж "Бууны дарга", "Тусгай холбооны шифрчин", "Цахилгаан холбоо, радио холбооны техникч", "Цацраг хими, биологийн ариутгагч", "Автын нярав" мэргэжлээр сурган дадлагажуулав.

"Цэргийн албаны бэлтгэл" сургалтын үйл ажиллагаатай ЗХЖШ-ын Бодлого, стратеги төлөвлөлтийн газрын Цэргийн дайчилгааны хэлтсийн дарга хурандаа Х.Банди, Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын орлогч дарга хурандаа Б.Эрдэнэпил нар танилцаж, сургалтад хамрагдсан бүрэлдэхүүнд үүрэг чиглэл өгсөн юм.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 20	🌧️ 4

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 38	🌧️ 27

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,121.00	3,126.0
EUR 🇪🇺	3,360.0	3,380.0
CNY 🇨🇳	463.00	466.00
RUB 🇷🇺	39.00	45.00
JPY 🇯🇵	24.55	24.75
KRW 🇰🇷	2.50	2.52

ЗУРХАЙ



2022.05.31 /МЯГМАР ГАРГАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 1

**ЗУНЫ ИЛҮҮ ТЭРГҮҮН САРЫН ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ХӨХ БИЧ ӨДӨР**

**Үс засуулбал:**

**НАС АХАР БОЛНО**

**НАРАН УРГАХ, ШИНГЭХ:**

**04.58-20.42**

**Барилдлага:**

**Хүчин төгсөх**

**Шүтэн барилдлага:**

**Төрөн түгэхүй**

**Суудал: Ус**

Энэ өдөр хулгана, луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, сүм дуганыг сэргээх, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, урлан бүтээхэд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийх, гөлөг тэжээхэд муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсоод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

**КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД**

**Тохиолдол**

Нийт: 532,022,559

**Эдгэрсэн**

Нийт: 503,073,367

**Нас барсан**

Нийт: 6,311,923

Цахим шууданд

**ЦЭРЭГ-СПОРТЫН "ДӨЛ-2022" ТЭМЦЭЭНИЙ АВАРГУУД ТОДОРЛОО**

**Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб**

Зэвсэгт хүчний 101, Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны 20 жилийн ойг тохиолдуулан Өвөрхангай аймгийн Засаг даргын нэрэмжит, аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг энэ сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгуулж явууллаа.

Аймгийн Засаг дарга А.Ишдорж тэмцээнийг нээж хэлсэн үгэндээ "Авьяаслаг, спортлог сурагчид маань "Дөл" тэмцээнд оролцсоноороо эх оронч хүмүүжил, төлөвшил, эх орноо батлан хамгаалах бие бялдрын болон сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр хатуужилд бүрэн суралцана гэдэгт итгэлтэй байна" хэмээн онцлоод дасгалжуулагч, баг тамирчид, сурагчдад спортын өндөр амжилтыг хүслээ.

Тэмцээний I шатны шалгаруулалтыг 5 дугаар сарын 1-ний дотор бүх сумын ерөнхий боловсролын сургуулиудын хэмжээнд зохион байгуулсан бөгөөд 14 сумаас шалгарсан 18 багийн 250 гаруй сурагч II шатны шалгаруулалтад оролцож,



гарааны өмнөх ажиллагаа, маршийн гүйлтийн тэмцээн гэсэн 2 ангиллаар цэрэг, спортын 12 төрөлд ур чадвар, авхаалж самбаа, тэсвэр хатуужлаа сорин өрсөлдсөн юм.

Нэгдсэн дүнгээр тэргүүн байрт Арвайхээр сумын ерөнхий боловсролын I сургууль, дэд байрт II сургууль, гутгаар байрт Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын сургууль, тусгай байрт Арвайхээр сумын

"Мэргэд" сургууль, Хужирт сумын ерөнхий боловсролын сургуулиуд тус тус шалгарав.

Аймгаасаа эхний 5 байрт шалгарсан баг тамирчдаас сонгон Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн ивээл дор, Батлан хамгаалахын сайдын нэрэмжит улсын аварга шалгаруулах "Дөл" тэмцээнд Өвөрхангай аймгаа төлөөлөн оролцуулах юм.

Дэд хурандаа Ч.ВАНЧИНСҮРЭН

**"ДӨЛ"-ИЙН ШИЛДГҮҮД ТОДОРЛОО**



**"Булган аймгийн Цэргийн штаб**

Аймгийн Засаг даргын захирамжаар Монгол Улсын баатар, хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн мэндэлсний 110 жилийн ойг тохиолдуулан Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг зохион байгуулан явууллаа. Тэмцээнд 12 сумын Ерөнхий боловсролын сургуулийн баг тамирчид оролцсон бөгөөд I байрт Сайхан сумын ЕБС-ийн "Галт баг" тасаг, II байрт Булган сумын 3 дугаар сургууль, III байрт Тэшиг сумын ЕБС-ийн "Шонхор" тасууд шалгарлаа.



Залуу жанжин Ж.Лхагвасүрэнгийн ач Л.Сэргэлэн тэмцээнд оролцсон шилдэг эрэгтэй тамирчин Хялганат тосгоны ЕБС-ийн 11а ангийн сурагч Г.Батжаргалд дурсамж, сэлэм, шилдэг эмэгтэй тамирчин Булган сумын ЕБС-ийн 11б ангийн сурагч О.Мягмаржаргалд дурсамж, ухаалаг цаг, тэргүүн байрт шалгарсан Сайхан сумын ЕБС-ийн "Галт" багийн сурагчдад гарын бэлгийг гардууллаа.

Ахмад Ц.ЦЭРЭНТОГТОХ

**"ОЛОН УЛСЫН ЭНХИЙГ САХИУЛАГЧДЫН ӨДӨР"-ӨӨР...**



**Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб**

"Олон улсын энхийг сахиулагчдын өдөр", Монгол цэрэг Энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан Сүхбаатар аймгийн цэргийн хүрээний ангиуд, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын энхийг сахиулагч алба хаагчдын оролцсон баярын хурлыг зохион байгууллаа.

Энэ үеэр Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад баяр хүргэн хүндэтгэл үзүүлж АИТХ-ын хүндэт өргөмжлөл, Аймгийн Засаг даргын Жуух бичиг, гарын бэлэг, мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа 12 байгууллагын гарын бэлгийг 130 гаруй энхийг сахиулагчид гардууллаа.

Ахмад Т.СУГАРЖАВ



**"ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРТЭЧ МОНГОЛ" АЯНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГААР ШАЛГАРЛАА**

**Зэвсэгт хүчний 325 дугаар анги**

Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар Биеийн тамир спортын газраас зохион байгуулсан "Илүүдэл жингүй-эртэч монгол" аяныг Завхан аймгийн Улиастай хотын ард иргэд 2 дугаар сарын 16-28-ныг хүртэлх хугацаанд үргэлжлүүлж хаалтын ажиллагаагаа зохион байгууллаа. Мөн Завхан аймгийн ЗДТГ болон Биеийн тамир, спортын газраас төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилчдын дунд "Эрчимтэй жин хасах" нэг сарын уралдааныг зохион байгуулж эрэгтэй, эмэгтэй тус бүр 3 байрыг эзлүүлэн шагнаж, урамшууллаа. Эрэгтэйчүүдийн төрөлд ахлагч А.Мандалсүрэн 10.3кг жин хасаж I байрт шалгаран 400000 төгрөг болон "Tsogt gem"-д гурван сар үнэгүй явах эрхийн бичгээр шагнууллаа. Мөн энэ үйл ажиллагааны үеэр "Илүүдэл жингүй-эртэч монгол" аянд идэвхтэй хамрагдсан ахлах ахлагч Э.Алтанцэцэг, дэд ахлагч Т.Оюунжаргал нарт ангийн захирагчийн тушаалаар баяр хүргэж "Дурсамж" болон Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр Монгол Улсын урлагийн гавьяат



зүтгэлтэн Л.Ванганы нэрэмжит Хөгжимт жүжгийн театрын хамт олны зохион байгуулж буй "Жангар" хүүхдийн концертыг хүүхдүүдтэйгээ үзэх тасалбараар шагнаж урамшууллаа. Уг хаалтын ажиллагаанд оролцохоор ирсэн бүрэлдэхүүний дунд азын сугалаа болон эрэгтэй, эмэгтэй уулын оргил булаалдах тэмцээнийг зохион байгуулсан юм. Эл тэмцээний

эрэгтэйчүүдийн төрөлд дэд ахлагч Ө.Лхагвасүрэн тэргүүн байрт шалгарлаа. "Илүүдэл жингүй-эртэч монгол" аяны хаалтын ажиллагаанд Завхан аймгийн ЗДТГ-ын дарга Г.Мягмарсүрэн оролцож аянд идэвхтэй оролцсон 3 байгууллагыг шалгаруулж тус бүр батламж 100000 төгрөгийн мөнгөн шагналаар шагнасан бөгөөд эл шагналын эзнээр тус анги шалгарлаа.

**ТҮҮХТ ОЙН ХҮРЭЭНД...**

**Зэвсэгт хүчний 338 дугаар анги**

Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойн хүрээнд сурталчилгааны ажлыг олон чиглэлээр зохион байгуулан явуулж байна. Уг ажлын хүрээнд Сүхбаатар аймгийн "BBS TV" телевизтэй хамтран энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн офицер, ахлагчийг алдаршуулах, энхийг сахиулах ажиллагааны туршлага, сургамж, бахархлын талаар олон нийтэд сурталчлах зорилгоор "Энхийг сахиулагчийн бахархал" сэдэвт захиалгат нэвтрүүлгийг бэлтгэн энэ сарын 29-нд олны хүртээл болгов.

Түүнчлэн түүхт 20 жилийн ойн хүрээнд Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн 1, 2, 4 дүгээр сургуулийн төгсөх ангийн сурагчдад "Эх оронч үзэл, үндэсний бахархал" сэдэвт яриа таниулга хийж сурагчдад эх орноо хайрлах сэтгэл, Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн түүхэн замнал зэрэг сонирхолтой сэдвээр яриа өрнүүлж асуулт, хариултын тэмцээн зохион байгуулан, шагнаж урамшууллаа. Арга хэмжээний төгсгөлд сурагчид Төрийн дууллаа дуулж, дурсгалын зургаа татуулсан юм.

Мөн Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний түүхт 20 жилийн ойг угтан ангийн эрэгтэй алба хаагчдын дунд 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, эмэгтэй алба хаагчдын дунд холын зайн шидэлтийн тэмцээнийг амжилттай зохион байгуулж аваргуудаа тодрууллаа. Үүнээс гадна Сүхбаатар аймаг үүсэн байгуулагдсаны 80 жилийн



ойн хүрээнд спортын мастер Ш.Энх-Амарын нэрэмжит уулын дугуйн улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдлаа. Уг тэмцээнд долоон аймгийн 11 байгууллага, клубийн нийт 95 тамирчин хурд

хүчээ сорин өрсөлдсөнөөс Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн мотобудлагын ротын нэгдүгээр салааны байлдагч Б.Нямсамбуу амжилттай оролцож VII байрт шалгарсан юм.

Дэслэгч Б.ПҮРЭВЛХАМ

Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ  
Батлан хамгаалах яам  
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС  
"Соёмбо" сонин  
"Дуулга" студи

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.  
\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.  
\* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018  
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029, 3412 (дотуур)